

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АГУУЛГА

2. Аудитын ТАЙЛАН	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал:	7
2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН	13
4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	13
4.2. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	14
4.3. Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	16
4.4. Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	18
4.5. Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/299
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал Г.Уянга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 19-нөөс 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Цэгцтөв богд аудит ХХК-ийн аудитор Н.Цэрэнханд, туслах аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эмгэг судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эмгэг судлалын үндэсний төв нь “Монгол Улсын Эмгэг судлалын шинжлэх ухааны тэргүүлэгч байхад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Эрүүл мэнд спортын сайдын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/294 тоот тушаал, MNS 6676:2017 дугаар стандартаар Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Өвчтөнөөс авсан амьд сорьц, эсийн түрхцэнд эд эсийн химийн шинжилгээ хийх оношлох
- Эмчлэгдэж байгаад нас барсан тохиолдолд эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, эмчилгээ оношлогооны тохиргоог шалган баталж клиникийн эмч нарын мэдлэг мэргэжил, хариуцлагыг дээшлүүлэх
- Онош зөрсөн ховор тохиолдолд эмгэг судлал эмнэл зүйн эмч нарын хамтарсан зөвлөлгөөнийг хийж эмчилгээ үйлчилгээний доголдол дутагдлыг шүүн хэлэлцэх,
- Орон нутгийн мэргэжил нэгт эмч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эмгэг судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
- Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа гол хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “E- Account” програм хангамж ашигладаг байна.

Эмгэг судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эмгэг судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 чиглэлд эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүжилт авдаг учир төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнтэй байдлыг хянаж дүгнэхтэй холбоотой юм.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны нийт зардал 1,628,753.7 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 16,287.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 асуудалд горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

№	Шийдэл	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал		Тайлбар
		Тоо	Дүн	
1	Зөвлөмж өгсөн	4	1,004.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	10,110.2	
3	Албан шаардлага өгсөн	2	2,424.7	
	Дүн	8	13,539.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Ажилчдад олгосон 37,255.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалаас 8,568,6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоогүй. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1-д “Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/ Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55,56,57,59,64,66,69 дүгээр зүйлд заасан олговор; Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллаас бүрдэнэ” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Суутган тооцоогүй нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох эздээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй олговорт нэг хүнд 1,541.8 мянган төгрөг цалинтай давхардуулан олгосон. Энэ нь Эрүүл мэнд, Нийгмийн Хамгааллын Сайдын 2000 оны 166 тоот тушаалын хавсралт ээлжийн амралтын зааврын 13-т “Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ээлжийн амралтын олговоргыг давхардуулж тооцсоныг төлүүлэн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох

2.8.1.3 Өмнөх аудитын зөвлөмжтэй холбоотой асуудал

Ажилтны сул орон тооны цалинг бүлэг дотроо үр дүнгийн урамшуулал бусад нэмэгдэлд зарцуулсан асуудалд өмнөх аудитаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитын орон тоо цалингийн санг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйн улмаас дутагдал дахин давтагдсан учир удирдлагад албан шаардлага өгөх

2.8.1.4 Балансын данстай холбоотой асуудал

Голомт банк дахь жижиг мөнгөн сангийн дансанд 2018 оны 9 дүгээр сарын 28-нд 59,185.1 мянган төгрөгийн орлого, орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсний урамшилд ирсэнийг 10, 11 саруудад зарцуулж дууссан. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмын 4.3-т “ Жижиг мөнгөн сангийн дээд хязгаар 3 сая төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Сангийн сайдын журам зөрчсөнд удирдлагад хариуцлага тооцож албан шаардлага өгөх

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалтын дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эмгэг судлалын үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд 1,274,886.3 мянга, нэмэлт төсөвт 16,595.9 мянга бүгд 1,291,482.2 мянган төгрөг батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсөвт зардлын гүйцэтгэл 1,283,594.8 мянган төгрөг буюу 99,4 хувь байгаа нь жирэмсэн, амаржсан ажилтан, сул орон тоонд төлөвлөсөн цалингийн сангаас шалтгаалжээ.

Тайлант онд улсын төсвөөс 1,200,882.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 82,712.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт зардлыг санхүүжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 12,002.0 мянга, сургалтыг дэмжих сангаас 25,895.0 мянга, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсний урамшуулалд 108,710.5 мянга, нийт 146,589.1 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.11. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Эмгэг судлалын үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Эмгэг судлалын үндэсний төв нь шилэн дансны тухай хуулийн дээрх заалтын дагуу урсгал үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт, бусад мэдээллийг ил тод болгон мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 88 хувьтай. Өмнөх аудитын зөвлөмжөөс орон тоо цалингийн санг бодитой төлөвлөж зарцуулах гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Учир нь эмгэг судлаач эмч нарын орон тоо шаардлагатай боловч ажиллах эмч олдохгүйн улмаас сул орон тоо үүссэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эмгэг судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт

Эмгэг судлалын үндэсний төвийн анхан шатны бүртгэл хөтлөлтийг шалгахад гарын үсгийн бүрдэл дутуу, хүчингүй болсон маягтаар бүртгэл хөтөлсөн нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл

Анхан шатны баримтын бүрдэл хангагдахгүй байх, хуулийн заалт, журам, заавар хэрэгжүүлээгүйн улмаар торгууль төлөх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтөлж, баримтыг бүрдлийг хангах

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтөлж бүрдлийг ханган ажиллах хариу ирүүлсэн.

3.2. Балансын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст 1,004.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн зарцуулалт алдагдах, найдваргүй авлага үүсэх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Хуулийн заалтыг хэрэгжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах хариу ирүүлсэн.

3.3. Балансын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Хувь хүнээс бараа материал худалдан аваад хувь хүний төлөх орлогын албан татварыг суутган тооцож зардалд бүртгэсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29.1.4-т “Суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ бүртгэлийн бичилт буруу хийсэн байна.

3.3.2. Эрсдэл:

УСНББОУС зөрчигдөх, бүртгэл буруу хөтлөгдөж санхүүгийн тайлангийн зардал буруу тооцогдох

3.3.3. Өгсөн зөвлөмж

Хувь хүний өглөг данснаас Хувь хүний орлогын албан татварын өглөг дансанд өглөг үүсгэн дансны бичилт хийж байх

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байхаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 5-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөг/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,606,073.80</u>	<u>2,442,568.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
		19,800.04	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	19,800.04	-
31140	Кассд байгаа бэлэн мөнгө -Төгрөг	19,800.04	
33	АВЛАГА	2,017,500.00	1,004,824.00
33402	Татвар, НДШ – ийн авлага	651,750.00	408,798.00
335	Бусад авлага	1,365,750.00	596,026.00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,365,750.00	596,026.00
35	БАРАА МАТЕРИАЛ	568,773.76	1,437,744.76
351	Түүхий эд материал	4,890.00	218,500.00
35110	Тусгай зориулалттай материал	4,890.00	218,500.00
354	Хангамжийн материал	563,883.76	1,219,244.76
35410	Бичиг хэргийн материал	92,462.50	8,512.50
35420	Аж ахуйн материал	204,660.00	162,640.00
35440	Түлш, шатах тослох материал	266,761.26	1,048,092.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>869,710,918.38</u>	<u>1,016,277,591.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	869,710,918.38	1,016,277,591.01
392	Биет хөрөнгө	869,414,807.33	1,016,181,479.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	576,612,506.67	584,190,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-295,992,870.39	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,207,000.00	35,207,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,474,405.95	-35,207,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	954,643,487.78	939,130,257.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-398,801,477.79	-541,336,504.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,965,040.00	60,164,440.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,744,472.99	-25,966,913.34
393	Биет бус хөрөнгө	296,111.05	96,111.04
39301	Програм хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-903,888.95	-1,103,888.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>872,316,992.18</u>	<u>1,018,720,159.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>872,316,992.18</u>	<u>1,018,720,159.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	872,316,992.18	1,018,720,159.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,401,756.70	368,401,756.70

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	368,401,756.70	368,401,756.70
512	Хуримтлагдсан үр дүн	503,915,235.48	385,961,492.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-62,208,009.99	503,915,235.48
51220	Тайлант үеийн үр дүн	566,123,245.47	-117,953,742.56
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		264,356,910.15
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>872,316,992.18</u>	<u>1,018,720,159.77</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,388,700,430.00	1,510,799,938.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,302,710.00	193,088,150.29
120	Нийтлэг татварын бус орлого	126,302,710.00	193,088,150.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,302,710.00	193,088,150.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,198,946.00	191,423,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	103,764.00	121,492.00
120009	Бусад орлого		1,543,358.29
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,262,397,720.00	1,317,711,788.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,222,191,920.00	1,279,814,788.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,120,517,400.00	1,225,982,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	101,674,520.00	53,832,588.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,205,800.00	37,897,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,029,000.00	12,002,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,176,800.00	22,824,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,071,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,450,908,439.99	1,627,726,460.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,450,908,439.99	1,627,726,460.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,310,536,943.17	1,435,521,760.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	757,647,950.03	795,219,311.15
210101	Үндсэн цалин	452,733,659.72	480,375,728.79
210102	Нэмэгдэл	304,914,290.31	128,907,716.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт		99,714,665.74
210104	Урамшуулал		86,221,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,731,787.72	101,018,358.85
210201	Тэтгэврийн даатгал	75,958,217.72	64,313,419.39
210202	Тэтгэмжийн даатгал		6,314,382.26
210203	ҮОМШӨ-ний даатгал		15,785,955.66
210204	Ажилгүйдлийн даатгал		1,578,595.56
210205	Эрүүл мэндийн даатгал	14,773,570.00	13,026,005.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,951,221.00	37,130,400.00

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	7,656,200.00	10,116,907.00
210302	Түлш, халаалт	12,171,221.00	11,056,734.00
210303	Цэвэр, бохир ус	6,123,800.00	15,156,759.00
210304	Байрны түрээс		800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,781,562.25	52,726,336.30
210401	Бичиг хэрэг	5,178,390.00	11,702,370.00
210402	Тээвэр, шатахуун	4,070,737.00	5,097,761.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,094,301.15	3,427,678.30
210404	Ном, хэвлэл		246,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,641,960.00	7,460,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	29,796,174.10	24,791,177.00
2105	Нормативт зардал	156,933,089.00	203,105,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	151,592,689.00	191,201,215.00
210502	Хоол, хүнс		3,999,955.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,340,400.00	7,904,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,066,150.00	2,859,489.00
210604	Урсгал засвар	4,066,150.00	2,859,489.00
2107	Томилолт, зочны зардал	2,362,900.00	6,058,900.00
210702	Дотоод албан томилолт	2,362,900.00	6,058,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,061,450.00	18,464,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,657,800.00	9,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	397,100.00	989,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	158,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		39,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,067,000.00	3,098,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,100.00	34,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	667,350.00	545,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,000,833.17	218,938,345.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,829,560.18	11,862,140.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	203,171,272.99	207,076,205.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,371,496.82	192,204,700.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,069,576.00	167,086,128.04
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,814,900.00	90,821,483.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,254,676.00	76,264,645.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,301,920.82	25,118,571.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,301,920.82	25,118,571.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-62,208,009.99	-116,926,522.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,027,219.98
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		1,027,219.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-1,027,219.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-62,208,009.99	-117,953,742.5

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1259110236.00</u>	<u>1455302500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125416036.00	191423300.00
120	Нийтлэг татварын бус орлого	125416036.00	191423300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125416036.00	191423300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125416036.00	191423300.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1133694200.00	1263879200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1120517400.00	1225982200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1120517400.00	1225982200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13176800.00	37897000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		12002000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13176800.00	22824000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3071000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1248650668.00</u>	<u>1418841700.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1248650668.00	1418841700.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1107289054.08	1226573800.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	756646072.03	793123377.29
210101	Үндсэн цалин	461210717.73	480375728.76
210102	Нэмэгдэл	295435354.30	126811782.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт		99714665.74
210104	Урамшуулал		86221200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92001138.62	100404008.42
210201	Тэтгэврийн даатгал	92001138.62	63699068.66
210202	Тэтгэмжийн даатгал		6314382.56
210203	ҮОМШӨ-ний даатгал		15785955.66
210204	Ажилгүйдлийн даатгал		1578595.56
210205	Эрүүл мэндийн даатгал		13026005.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25951221.00	37130400.00
210301	Гэрэл, цахилгаан	7656200.00	8918700.00
210302	Түлш, халаалт	12171221.00	12182700.00
210303	Цэвэр, бохир ус	6123800.00	15229000.00
210304	Байрны түрээс		800000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48035062.25	50813359.30
210401	Бичиг хэрэг	5649780.00	11401080.00
210402	Тээвэр, шатахуун	3828500.00	5757600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1094301.15	4067578.30
210404	Ном, хэвлэл		249400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8028030.00	7234000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	29434451.10	22103701.00
2105	Нормативт зардал	156134900.00	203368755.00

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	151193600.00	191427500.00
210502	Хоол, хүнс		3999955.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4941300.00	7941300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3767700.00	3767700.00
210604	Урсгал засвар	3767700.00	3767700.00
2107	Томилолт, зочны зардал	2362900.00	4618900.00
210702	Дотоод албан томилолт	2362900.00	4618900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14384100.00	18909500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9657800.00	9600000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	4000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	397100.00	989000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70100.00	158400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		39600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3067000.00	3098000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2100.00	34500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990000.00	990000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8005960.18	14437800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8005960.18	14437800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141361613.92	192267900.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	67059693.10	167149328.04
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32814900.00	90821483.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34244793.10	76327845.04
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74301920.82	25118571.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74301920.82	25118571.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10459568.00</u>	<u>36460799.96</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>10442300.00</u>	<u>36480600.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>10442300.00</u>	<u>36480600.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	10442300.00	36480600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10442300.00	36480600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-10442300.00</u>	<u>-36480600.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17268.00	-19800.04
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2532.04	19800.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19800.04	0.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөг /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70		566,123,245.47		934,525,002.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	0.00	566,123,245.47	0.00	934,525,002.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн			-62,208,009.99		-62,208,009.99
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	0.00	503,915,235.48	0.00	872,316,992.18
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	0.00	503,915,235.48	0.00	872,316,992.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	0.00	503,915,235.48	0.00	872,316,992.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		264,356,910.15			264,356,910.15
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн			-117,953,742.56		-117,953,742.56
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	385,961,492.92	0.00	1,018,720,159.77

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,291,472,200.00	1,283,594,792.01	7,877,407.99	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,291,472,200.00	1,283,594,792.01	7,877,407.99	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,200,650,700.00	1,192,773,309.01	7,877,390.99	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	793,825,300.00	789,297,783.29	4,527,516.71	99.4
210101	Үндсэн цалин	479,985,700.00	476,550,134.76	3,435,565.24	99.3
210102	Нэмэгдэл	130,663,800.00	126,811,782.79	3,852,017.21	97.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,964,600.00	99,714,665.74	-2,750,065.74	102.8
210104	Урамшуулал	86,211,200.00	86,221,200.00	-10,000.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,198,600.00	99,848,762.42	3,349,837.58	96.8
210201	Тэтгэврийн даатгал	63,506,824.00	63,143,822.66	363,001.34	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,350,682.40	6,314,382.26	36,300.14	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,876,706.00	15,785,955.66	90,750.34	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,587,971.40	1,578,595.56	9,375.84	99.4
210205	Эрүүл мэндийн даатгал	15,876,416.20	13,026,006.28	2,850,409.92	82.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,330,400.00	36,330,400.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,918,700.00	8,918,700.00	-	100.0
210302	Түлш, халаалт	12,182,700.00	12,182,700.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	15,229,000.00	15,229,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,010,800.00	35,010,763.30	36.70	99.999
210401	Бичиг хэрэг	3,309,000.00	3,309,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,486,600.00	5,397,600.00	89,000.00	98.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,578,600.00	1,667,578.30	-88,978.30	105.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,234,000.00	7,234,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,402,600.00	17,402,585.00	15.00	99.999
2105	Нормативт зардал	190,368,800.00	190,368,800.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	185,427,500.00	185,427,500.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,941,300.00	4,941,300.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,678,900.00	22,678,900.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,911,200.00	18,911,200.00	-	100.0

Эмгэг судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	3,767,700.00	3,767,700.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,362,900.00	2,362,900.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	2,362,900.00	2,362,900.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,875,000.00	16,875,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	9,600,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	989,000.00	989,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	158,400.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,098,000.00	3,098,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	990,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,821,500.00	90,821,483.00	17.00	99.999
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,821,500.00	90,821,483.00	17.00	99.999
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	90,821,500.00	90,821,483.00	17.00	99.999
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,291,482,200.00	1,283,594,792.01	7,887,407.99	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,225,982,200.00	1,200,881,992.01	25,100,207.99	98.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,225,982,200.00	1,200,881,992.01	25,100,207.99	98.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,500,000.00	82,712,800.00	-17,212,800.00	126.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,500,000.00	82,712,800.00	-17,212,800.00	126.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	68.00	63.00	5.00	92.6
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	55.00	51.00	4.00	92.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	12.00	1.00	92.3

5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	2019.02.20	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Эмгэг судлалын үндэсний төв			САГ-2019/8/СТА-ТШЗ
				Мянган төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Амралтын цалин давхардуулан олгосон	1,541.6	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ахлах нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
Жижиг мөнгөн сангийн хязгаарыг хэтрүүлсэн	2,424.7	зөвлөмж		
Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг зөрчсөн		Албан шаардлага		
Ажилчдад олгосон урамшуулалаас нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй.	8,568.6	Төлбөрийн акт тогтоох		
Зардлын дансанд Хувь хүний орлогын албан татварын өглөг данснаас бичилт хийсэн	0	зөвлөмж		
Авлага үүсгэсэн	1,004.8	зөвлөмж		
Анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй	0	зөвлөмж		
Зөвлөмжийн дүн	13,539.7			

